

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022 оны 12 сарын 12

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв сая төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	хувь
Мал аж ахуйн салбар:							
1	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах	ОНТ 500,0	Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангасан хувь	80,8	81	Засгийн газрын 2022 оны 222 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах шалгуур үзүүлэлтийн дагуу Аймгийн Засаг даргын 10 сарын 17-ны өдрийн А/406 тоот захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай танилцсан. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 86,3 хувьтай хангагдсан.	100
2	Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх		Зарцуулах хөрөнгийн хэмжээ хувиар	0	30	Аймгийн хэмжээнд малын тоо толгойн албан татвар 1,382,829,000 төгрөг төвлөрснөөс дараах чиглэлүүдэд зарцуулав. Бэлчээрийн менежмент-25,0 сая, усан хангамж-445,7 сая, малын эрүүл мэндийг хамгаалах-92,5 сая, малын чанар сайжруулах-27,1 сая, хур тунадас-12,0 сая, тэжээлийн ургамал тариалах-14,9 сая, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх-145,7 сая, Байгаль орчныг хамгаалахад-17,0 сая, хортон мэрэгчтэй тэмцэх-43,8 сая, сургалт-32,7 сая төгрөг нийт 839,2 сая төгрөг буюу нийт төвлөрсөн хөрөнгийн 61 хувийг Мал аж ахуй болон хөдөө аж ахуйн салбарт зарцуулсан.	100
3	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах	Хувийн хэвшил	Тухайн жилд эдийн засгийн эргэлтэд оруулсан мал	83017	24905	Таваарын буюу хэрэгцээний 750915 малаас 498286 малыг зах зээлд борлуулж эдийн засгийн эргэлтэд оруулаад байна.	100

4	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр 825,6 сая.төг	Тухайн жилд шинээр гаргасан худгийн тоо	44	15	Төсөл хөтөлбөр, Орон нутгийн төсвийн 736,6 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдад инженерийн хийцтэй 25 худаг, Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдад 27 цооногийг гаргаж бэлчээр усжуулалтыг 1,5 хувиар нэмэгдүүлсэн.	100
			Тухайн жилд сэргээн засварласан худгийн тоо	42	7	Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 74,0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд 32 энгийн уурхайн худгийг сэргээн засварласан.	
			Хашсан булгийн эхийн тоо	0	3	ОНТ-ийн 15,0 сая төгрөгийн санхүүжилтээр Хулд, Луус, Сайхан-Овоо сумдад 3-н булгийн эхийг хашиж хамгаалсан.	
5	Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх	ОНТ 48.0	185-р тогтоолын хэрэгжилт хувь	83	84	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 185 дугаар тогтоол “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/166 захирамжаар Орон нутгийн төсөв 43,8 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар 29,5 мянган га талбайд тэмцэж, хээрийн техникийн үр дүн 84 хувьтай тэмцсэн.	100
6	Малчдыг дэмжих анхдугаар аяныг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	ОНТ 25,0	Аянд хамрагдсан малчдын тоо	0	150	Хүний хөгжлийг дэмжих жил, Монгол малчин үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Малчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллээр хангах ажлын хүрээнд малчдын зөвлөгөөнийг 04 сарын 26 өдрөөс 05 сарын 27ны хооронд 15-н суманд холбогдох байгууллагууд хамтран амжилттай зохион байгуулсан. Зөвлөгөөнд нийт 3626 малчин хамрагдсан.	100
7	Орон нутгийн тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын нөөц	-	Хөрөнгө оруулалт хийгдсэн	74,3	3,0	Аймгийн ИТХурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай 15 дугаар тогтоолоор Дэлгэрхангай, Өлзийт, Сайхан-	30

	бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах		талбайн хэмжээ мян/га			Овоо, Эрдэнэдалай сумдын 64,9 мянган га талбайг сум дундын отрын тусгай хэрэгцээнд авсан, тогтоолоор батлагдсан талбайн хэмжээг Ашигт малтмал газрын тосны газрын хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн албан тоотоор дээрх газруудын 37,0 мянган га талбай сум дундын отрын бүс нутгийн давхцалтай байгаа тул Геологи, уул уурхайн бүртгэлд бүртгэх боломжгүй гэсэн албан тоот ирсэн.	
8	Мал аж ахуйн нэгдсэн мэдээллийн системд мэдээлэл оруулах	-	Тухайн жилд Системд оруулсан малын мэдээллийн тоо	21100	1055	Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах ажлын хүрээнд нийтдээ 6400 малыг МААНэгдсэн системд оруулсан.	100
9	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт хийж цөм сүргийг бүрдүүлэн /airs.mofa.gov.mn/, /muz.gov.mn/-үүдэд мэдээллийн сан бүрдүүлэх	-	Тухайн жилд мэдээллийн санд бүртгэсэн малын тоо	16800	1680	Сайнцагаан сумын Сайнцагаан омгийн хонь, Өндөршил сумын Өндөршил омгийн адуу, Хулд сумын Олдохын хүрэн бор омгийн тэмээнд үзлэг ангилалт хийж малын Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийтдээ 6400 мал оруулсан.	100
10	Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгчийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн /airs.mofa.gov.mn/-д бүртгэж мэдээллийн сан бүрдүүлэх	-	Тухайн жилд Мэдээллийн санд бүртгэсэн хээлтэгч,хээлтүүлэгч малын тоо	4300	1290	Цөм сүргийн болон үржлийн сүргийн 1972 хээлтэгч болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж /airs.mofa.gov.mn/-д бүртгэж мэдээллийн санг бүрдүүллээ.	100
11	Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад шилжүүлж ялган төвлөрүүлэх	Хувь хөрөнгө	Ялган суурилсан хээлтүүлэгч малын тоо	4128	5367	Хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялган суурилсан хуц 6705, ухна 5358 бүгд 12063 хээлтүүлэгч ялган суурилсан. Ялгавал зохих хээлтүүлэгч малын 63 хувийг ялган суурилж өмнөх оноос 34 хувиар нэмэгдүүллээ.	100

12	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн нэгж байгуулах, дэмжиж ажиллах	Хувь хөрөнгө-5,0	Дэмжиж ажилласан ААН-ийн тоо	3	4	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мал үржүүлэг технологийн 4 аж ахуй нэгжийг дэмжин сумдтай гэрээ байгуулан ажиллуулж байна.	100
13	Сумын хөдөө аж ахуйн тасгийг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, бүтэц орон тоогоор нь ажиллуулах	ОНТ	Мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь	44,4	46,6	ХХААСалбарын мэргэжилтэй боловсон хүчин 57 байхаас 30 албан хаагч ажиллаж, 2 суманд 2 мэргэжилтэн шинээр ажилд орж боловсон хүчний хангамж 52,6 хувьтай байна.	100
14	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилтийн төслөөс хийгдэх ажлыг хамтран хэрэгжүүлэх	Төсөл хөтөлбөр 412,0	Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийн тоо	10	7	Орон нутгийн хөгжлийн сан, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл 224,0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Дэлгэрхангай, Өлзийт, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдад инженерийн хийцтэй 7 худгийг шинээр гаргаж ашиглалтад оруулсан.	100
			Шинээр барих өвс тэжээлийн агуулахын тоо	1	1	440,0 сая төгрөгийн санхүүжилтээр Аймгийн Засаг даргын өвс, тэжээлийн агуулахын барилгыг ашиглалтад оруулсан.	
			Шинээр барих борлуулалтын цэгийн тоо	1	1	Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, зах зээлд зуучлах “Дундговьд үйлдвэрлэв” борлуулалтын төв шинээр ашиглалтад оруулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломж бүрдэж өнөөгийн байдлаар 130 гаруй үйлдвэрлэгч бараа бүтээгдэхүүнээ дэлгэн 142,0 сая төгрөгийн борлуулалт хийжээ.	
Газар тариалангийн салбар:							
15	Тариалалтын төлөвлөгөөг орон нутгаас ирүүлсэн саналыг үндэслэн эцэслэн боловсруулж даалгавар	Хувийн хэвшил-30,0	Тариалах талбайн хэмжээ га	65.9	79	Нийт 79 га-д талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөн ажилласан. Үүнээс: Аймгийн хэмжээнд 23 ААН, 153 иргэн 2022 онд нийт 71,9 га-д төмс	24.5

	болгон хүргүүлж байгаа тул таримал тус бүрээр тариалах талбай, хураан авах ургацын хэмжээг тооцож орон нутагт хүргүүлж эзэнжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах (Тариалах талбай, хураан авах ургац, боловсруулах уриншийн төлөвлөгөөг хавсаргав)		Хураан авах ургацын хэмжээ тн	418.8	515	хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалж төлөвлөсөн хэмжээнээс талбайн хэмжээ 7.1 га-гаар буурч, талбай харьцуулалт 91 хувьтай байна. Ургац хураалтаар нийт 71,9 га-аас 423,2 тн-ийг хурааж, урьд онтой харьцуулахад 4.4 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
16	10-аас дээш жилийн насжилттай, шинэчилбэл зохих техникийн судалгааг сум, иргэн аж ахуйн нэгжээр, техникийн төрөл, маркаар гаргаж ирүүлэх	1	Судалгаа гаргасан тоогоор	1	1	Техник, тоног төхөөрөмжийн судалгааг ХХААХҮЯамны ГТХБЗГ-т цахим шуудангаар 1 удаа хүргүүлэн ажилласан.	100
17	Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг нэмэгдүүлэх	0	Механикжуулалтын түвшинг хувиар	0	5	1.“Шинэ хөдөө” төслийн хүрээнд төслийн хүрээнд Сайнцагаан суманд 80 морины хүчтэй трактор, үрлэгч, анжис, дуслын усалгааны систем /5000м2/, намираа усалгааны хоолой, хамгаалалтын төмөр хашаа-100ш, зуны хүлэмж, усны нөөц сав-4ш, инженерийн хийцтэй худаг-1ш зэрэг нийт 9 нэр төрлийн 162 гаруй сая төгрөг Мөн Луус суманд 50 морины хүчтэй трактор, Баянжаргалан суманд мотоблок /дагалдах хэрэгсэлтэй/, дуслын усалгааны систем /5000м2/, усны нөөц сав-4ш, зуны хүлэмж-6ш, хамгаалалтын төмөр хашаа-31ш, инженерийн хийцтэй худаг-1ш нийт 6 нэр төрлийн 72 орчим сая төгрөг, аймгийн хэмжээнд нийт 297,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. 2. Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага” “Гамшигт тэсвэртэй орон нутаг төсөл”-ийн 51,0 сая төгрөгийн санхүүжилтээр Дэрэн суманд 25 морины	100

						хүчтэй трактор, үрлэгч, прэслэгч, гар хадуур, цахилгаан хадуур, анжсийг дагалдах иж бүрдлийн хамт нийлүүлсэн. 3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын ойн ангид 50 морины хүчтэй трактор, нүх ухагч, бул, анжисийг тус тус нийлүүлсэн. Ингэснээр аймгийн механикжуулалтын түвшин 5%-д хүрсэн байна.	
18	Аймгийн санаачилга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1000м ² талбайтай өвлийн хүлэмж, 2000м ² талбайтай зуны хүлэмж байгуулж тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Хувийн хэвшил-35,0	Өвлийн хүлэмжид тариалсан талбай хэмжээ м.кв	1540	1540	Өвлийн хүлэмжид 1780 м.кв тариалалт хийсэн. Урд онтой харьцуулахад 240 м.кв нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 17,4 тн ургац хураан авч, урд оноос 10,3 тн-оор нэмэгдсэн.	98.5
			Зуны хүлэмжид тариалсан талбай хэмжээ м.кв	11223	13223	Аймгийн хэмжээнд энэ онд зуны 108 ш хүлэмжид буюу 12719 м2 талбайд тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 1496 м2 талбайгаар шинээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ онд хүлэмжээс 71.5 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 14,9 тн –оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ургац хураалтын эцсийн дүнтэй харьцуулж тооцоход Аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт хүнсний ногооны 2,4 хувийг хангаж байна.	
19	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд өөрийн орон нутагт жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч тариалалтыг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлэх, 1-ээс доошгүй суманд 10 га талбай бүхий 1 агро-ойн аж ахуй, 3-аас доошгүй	Хувийн хэвшил-20,0 ОНТ-90,0	Шинээр нэмэгдүүлсэн талбай хэмжээ га	56,7	62	2022 онд шинээр 14,6 га-д тариалалт хийж, аймгийн хэмжээнд жимс жимсгэнийн 71,3 га талбайтай болсон. Урд онтой харьцуулахад 9,3 га -аар нэмэгдсэн байна.	100
			Өмнөх оноос нэмэгдсэн ургацын хэмжээ тн	2,6	2,86	Жимс, жимсгэнэ 4,5 тн-ийг хураан авч, урд онтой харьцуулахад 1,9 тн-оор нэмэгдсэн байна.	
			Сайнцагаан суманд шинээр агро	-	2	Сайнцагаан суманд агро ойн аж ахуй, төмс хүнсний ногоо тариалах "АГРОПАРК"-ийн эхлэл тавигдлаа. Шинээр 2 га талбайг ОНХС-ийн хөрөнгөөр 90 сая	

	багт 5 га талбай бүхий агро-ойн аж ахуй байгуулах, жимсний суулгацын палантаци байгуулахыг дэмжиж ажиллах		ойн аж ахуй байгуулах га-гаар			төгрөгөөр хашаа, гүний худаг, цахилгаан хангамжийн асуудлыг шийдэж өгснөөр “Говийн шимт ургац” ТББ, иргэдийн бүлэг нэгдэн ил талбайн болон хүлэмжийн 20 гаруй нэр төрлийн хүнсний ногоог тариалсан байна. Үүний үр дүнд газар тариаланг хөгжүүлэх, хүнсний ногоо тариалах иргэдийн идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд томоохон дэмжлэг боллоо.	
20	Газар тариалангийн салбарын мэдээ тайланг өгөгдсөн маягтын дагуу цаг хугацаанд нь ирүүлж, тариалангийн үйлдвэрлэлийг шуурхай зохион байгуулж ажиллах	0	Тайлангийн тоо	25	30	Тайлан мэдээ өгөх хуваарийн дагуу тариалалтын бэлтгэл болон салбарын холбогдолтой бусад мэдээллийг хугацаанд нь давхардсан тоогоор нийт 30 удаа гаргаж хүргүүлэн ажилласан.	100
21	Төмсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх аймгийнхаа хэрэгцээг хангах, мэдээ тайланг бүрэн, үнэн зөв авч хугацаанд нь тайлагнах	Хувийн хэвшил-10,0	Тариалах талбайн хэмжээ га	28	28	Төмс 29.4 га-аас 234.4 тн-ийг хураан авсан байна.	51.6
			Хураан авах ургацын хэмжээ тн	233	279		
			Хангамжийг хувиар	14,5	15	Аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 14,6 хувийг хангаж байна.	
22	Хүнсний ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг сум бүрд 20 га-р нэмэгдүүлэх, шинээр газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах	Хувийн хэвшил-10,0	Хөтөлбөрийн хэрэгжилт хувь	100	100	Хүнсний ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг 100 ханган ажиллалаа.	65.5
			Шинээр нэмэгдүүлсэн талбай хэмжээ га	19,5	21	Хүнсний ногоо 21,5 га-аас 176,2 тн-ийг хураан авсан байна.	
			Хураан авах ургацын хэмжээ тн	162,3	207		

23	Тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах, шинжилгээний дүнгийн нэгтгэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ирүүлэх	Хувийн хэвшил-60,0	Тайлангийн тоо	1	1	Хөдөө аж ахуйн их сургууль болон НҮБ хамтран аймгийн хэмжээнд явуулсан хээрийн судалгааны ажлын явцад авсан хөрс болон ургамлын дээжийн задлан шинжилгээг ХААИС-ийн итгэмжлэгдсэн лабораторид хийсэн. Үүнд: 15 сумын 736,6 га талбайгаас 160 цэгт ургамал болон хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэн мэдээллийн санд хадгалсан.	100
24	Тариалангийн талбайг хашаажуулах, хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах	ОНТ-12,5 УТ-20,0	Шинээр нэмэгдүүлсэн талбай хэмжээ га	50,7	55	Энэ онд ойн зурвас шинээр байгуулсан сумд: Өлзийт 2 га, Дэлгэрхангай 2 га, Говь-Угтаал 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулж, нийт 55,7 га-д хүрсэн байна.	100
25	Услалтын системийн барилга байгууламжийг паспортжуулах ажлыг Барилгын тухай хууль, Усны тухай хуульд заасны дагуу үргэлжлүүлж хийх, услалтын системүүдийн бүртгэлийг нарийвчлан гаргах	0	Тайлангийн тоо	1	1	Услалтын системийн тайланг 1 удаа ХХААХҮЯамны ГТБХЗГ-т хүргүүлэн ажиллалаа.	100
26	Ургамал хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт организмыг устгах ажлыг зохион байгуулах	0	Хасах заалт	-		Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран Эрдэнэдалай, Сайнцагаан, Адаацаг сумдын аж ахуй нэгж, иргэдийн тариалсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмжийн тарималд тархаж хөнөөл учруулж буй хортон шавж, ургамлын өвчин, хог ургамал, мэрэгч амьтдын төрөл зүйлийг илрүүлэх, бүртгэх, тархалт, хөнөөлийг тодорхойлох, зэрэг ажлыг хамтран хийлээ.	100

27	Ургамал хамгааллын бодис бордооны зохистой хэрэглээ төлөвшүүлэхэд хяналт тавьж ажиллах	0	Сургалтын тоо	1	3	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон "Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв", Жайка ОУБ-ын "SHEP" буюу "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Хүнсний ногооны тариалан эрхлэх, ногооны аж ахуйг хөгжүүлэх арга сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад хүнсний ногоо тариалах сонирхолтой 11 сумын 66 тариалан эрхлэгчид хамрагдсан. Аймгийн ЗДТГ-аас санаачлан, дэмжлэг үзүүлж, БОАЖГ, "Эх дэлхийгээ аваръя жиргээ холбоо" нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай хамтран "Дундговio ногооруулъя" хөтөлбөрийн хүрээнд сумдад байгуулагдсан бүлгийн ахлагчид, ахмад тариаланчид, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид нийт 110 тариалан эрхлэгчийг оролцсон. Мод бут, жимс жимсгэнэ тарих арчлах хамгаалах, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн нарийн ногоо тариалах, цэцэг арчлах зэрэг арга зүйн болон бодит туршлага хуримтлуулах 2 өдрийн сургалтад хамтран ажиллалаа. Сургалтад хамрагдсан тариаланчид өвлийн нарлаг хүлэмжийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлуулсан.	100
			Хамрагдсан иргэдийн тоо	22	100		
28	Газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөдөө аж ахуйн зохистой дадал, эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх	Төсөл хөтөлбөр-3,0	Сургалтын тоо	1	2	Өрхийн тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ХХААГ, Сайнцагаан сумын ЗДТГ, МХГ-тай хамтран "Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглаж буй ургамал хамгааллын бодис, бордооны чанар, зохистой хэрэглээ, аюулгүй ажиллагааг ханган ажиллах" сургалтад газар тариалан эрхлэгч нийт 40, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон "Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв", Жайка ОУБ-ын "SHEP" буюу "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Хүнсний	66.6
			Хамрагдсан иргэдийн тоо	30	70		

			Гэрчилгээ олгосон иргэдийн тоо	-	3	ногооны тариалан эрхлэх, ногооны аж ахуйг хөгжүүлэх арга сэдэвт сургалтад 66, нийт 106 тариалан эрхлэгч сургалтад хамрагдсан.	
Хүнсний үйлдвэрийн салбар:							
29	Гол нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тэнцлийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн олон улсын жишигт нийцүүлэн улирал тутам бодитой гаргах	Хувийн хэвшил	Мэдээллийн тоо	2	4	Аймгийн жишсэн дундаж хүн амын хүнсний гол нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүний хангамжийг орон нутгийн үйлдвэрлэл болон худалдаанд байгаа хүнсний бүтээгдэхүүний хэмжээгээр улирал бүр тооцон ажиллаж байна. 12 нэр төрлийн хүнсний нөөцийн мэдээг /foodsupply.mofa.gov.mn/ вэб дээр суурилсан программд оруулж, ХХААХҮЯ-д 60 удаа хүргүүлсэн. Хүн амын хэрэгцээт талх нарийн боов- 215,6 тонныг үйлдвэрлэж -8,5 хувийг, мах, махан бүтээгдэхүүн - 359,8 тонныг үйлдвэрлэж -21,3 хувийг сүү,сүүн бүтээгдэхүүн -7,4 мян.л-ийг үйлдвэрлэж 0,2 хувийг, өндөг 47,2 тонныг үйлдвэрлэж 16,8 хувийг тус тус хангасан байна.	100
30	Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж дүгнэх, тайлагнах	Хувийн хэвшил	Тухайн оны нөөцийн хэмжээ тн	162	100	Орон нутгийн хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээг хангах, үнийг тогтвортой байлгах зорилгоор хонь-108тн, ямаа-44.5 тн мах буюу 152,5 махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлж хүний амын хэрэгцээнд нийлүүлсэн. -2023 оны өвөл хаврын нөөцөд 496107 толгой мал буюу 10628,9 тн мах бэлтгэх судалгаа байна. -Нөөцийн махны талаарх мэдээ тайланг холбогдох газруудад 4 удаа гаргаж өгсөн байна.	100
			Тайлангийн тоо	2	2		
31	Органик үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор орон нутагт хамтын баталгаажуулалтын байгууллагыг байгуулах идэвх санаачилгыг	-	Хамтын баталгаажуулалтын байгууллагын тоо	0	1	Сайнцагаан сумын Хүлэмжийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Хүрээн-Ус хоршоо” нь Эс Эф Си Эс ХХК-ний Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн баталгаажуулалтын төвд Хөдөө аж ахуйн зохистой зохистой дадал нэвтрүүлэх хүсэлтээ өгснөөр тус байгууллагын аудитын хяналт, шалгаруулалтаар орж Хөдөө аж ахуйн зохистой	70

	дэмжиж ажиллах, үр дүнг тооцож, тайлагнах					дадал нэвтрүүлж баталгаажсан “Гэрчилгээ” авах шаардлагыг хангаж гэрээ байгуулахаар ажиллаж байна. Энэ нь цаашдаа Органик үйлдвэрлэлийг бий болгох хамтын баталгаажуулалтын байгууллага үүсгэн байгуулахад их ач холбогдолтой.	
32	Хими, барилгын материал, малын эмийн савыг хүнсний зориулалтаар ашиглаж буйг шат дараалалтай хүнсний зориулалтын саваар солих арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах	-	Хүнсний зориулалтын савтай өрхийн тоо	50	75	Сумд Малчдын зөвлөгөөн, бусад арга хэмжээний үеэр хүнсний зориулалтын болон зориулалтын бус савны тэмдэг тэмдэглэгээний талаар зөвлөмж, гарын авлага материалыг нийт 300 орчим иргэнд өгч ажиллажээ. Үүний үр дүнд 150 айл өрх сүү, цагаан идээ, ундны усны саваа хүнсний зориулалтын саваар сольсон байна. Мөн аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний үеэр хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ явуулсан 84 иргэн аж ахуйн нэгжид хүнсний зориулалтын хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний мэдээлэл зөвлөмжийг өгч ажилласан.	100
33	Аймаг, орон нутагт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн түвшинг тодорхойлсон судалгаа хийж, үр дүнг тооцон, тайлагнах	-	Тайлангийн тоо	0	1	Аймгийн хэмжээнд 58 иргэн аж ахуйн нэгж үйл хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаагаас 21 Ресторан, Зоогийн газар, кафе, 37 цайны газар үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 283 хүн ажилладаг. Дээрх газруудад хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн түвшинг тодорхойлсон судалгаа гаргаж тайланг холбогдох газарт нь хүргүүлсэн.	100
Хөнгөн үйлдвэрийн салбар:							
34	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах	ОНТ	сая.төг	1,607.2	1,767.92	Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч иргэн ААНэгжээс аймгийн хэмжээнд талх нарийн боов, төмс хүнсний ногоо, мах, сүү гэх мэт 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний 320 гаруй сая төгрөгийн худалдан авалт хийсэн. ОНӨГ-өөс зарлагдсан 43 тендерийн шалгаруулалтын 11 тендерт орон нутгийн аж ахуйн нэгж гүйцэтгэгчээр шалгарч 1,337,091,015 төгрөгийн гэрээ байгуулснаар орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оноос 75 хувь болж өссөн.	70

35	Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх	Хувийн хэвшил, хоршоод	Арьс шир хуулах төхөөрөмжийн ашиглалтын хувь	-	12	2021 онд ХХААХҮЯ, Судалгаа хөгжлийн төв, UNIDO төсөл хамтран Дундговь аймагт малын арьс, шир өвчиж хуулах SFF төхөөрөмжийг “Шувуутайн Оргил” мал төхөөрөх цехэд суурилуулж 2022 онд нийт бодын шир 325 ширхгийг хуулж бэлтгэсэн нь өдрийн хүчин чадлын 13,3 хувийг ашигласан үзүүлэлттэй байна. Сүүлийн хагас жилд зөөврийн 380 квт-ын хүчдэл ашиглаж байсныг эзэмшигч нь авсны улмаас ашиглах боломжгүй хүчдэл буулгах ажил хийгдэхээр хүлээгдэж байна.	100
			Бэлтгэсэн арьс, ширний хэмжээ	55280	61258	2022 онд нийт 5 төрлийн малын арьс шир 61258 ширхгийг зах зээлд бэлтгэн нийлүүлсэн.	
			Үүнээс үйлдвэрт тушаасан	25860	27566	Итгэмжлэгдсэн 11 хоршоогоор дамжуулан 27566 ширхэг арьс нэхийг үндэсний үйлдвэрт тушаасан.	
36	Ноосон түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх	Шинэ хөдөө төсөл - 199,9 Хоршоод, ТББ, хувийн хэвшил - 30,0	Хонь хяргах төхөөрөмжөөр хангагдсан бүлгийн тоо	1	6	Монгол Улс дахь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч ВИНОД АХУЖА НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудыг танилцуулж тус байгууллагын санхүүжилтээр хийгдсэн 15 сумын залуу малчдыг чадавхжуулах сургалтад хамрагдсан малчдад сүүлийн үеийн дэвшилтэд технологи болох хонь хяргах машиныг тус бүр 1 ширхгийг өгсөн.	93,2
			Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	15,0	80,0	Шинэ хөдөө төслийн хүрээнд Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж нийт 199.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.	
			Хяргах машинаар ноосолсон малын тоо	500	600	Сайнцагаан суманд цахилгаан хайчаар хонь хяргах сургалтыг зохион байгуулж 300 хонь хяргасан.	
			Зохион байгуулсан	1	2	Монголчуудтайгаа туршлага хуваалцъя төрийн бус байгууллага, Sheare mongolia олон улсын байгууллагатай хамтран 4-н аймагт болсон сургалтад	

			арга хэмжээний тоо			3 сумын 13 малчинтай оролцсон. Мөн Сайнцагаан суманд 10 иргэнд цахилгаан хайчаар хонь хяргах сургалтыг зохион байгуулсан.	
			Хамруулсан хоршоо, малчдын тоо	9	20	23 малчдыг сургалтад хамруулсан.	
37	Дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн холбоог түшиглэн сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх	-	Сургалтын тоо	2	2	Мерит төсөлтэй хамтарсан ЖДҮҮЭ-ийг чадавхжуулах Модуль-3 сургалтад давхардсан 24 үйлдвэрлэгч, ХХҮГ-тай хамтарсан боловсруулсан арьс ширээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтад 20 гаруй үйлдвэрлэгчийг хамруулан сургалаа. Мөн орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг Төв аймгийн Баянчандмань сумын сүү, ногоо, тахиа, салфетканы үйлдвэрүүд болон Улаанбаатар хотын “Цэвэр хөрсний шим” дундын хоршооны мөн Хэнтий аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сумдад зохион байгуулагдсан аялалд 10 хүнийг хамруулж нийт 34 иргэнийг сургалтад хамрууллаа.	100
		-	Хамрагдсан иргэдийн тоо	22	30		
Жижиг, дунд үйлдвэрийн салбар:							
38	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх	ЖДҮХСан болон бусад төсөл хөтөлбөр	Сая.төг	ЗБДСан – 90,0	ЖДҮХСа н – 220,0	ЖДҮХС, ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 2022 онд нийт 18 төсөлд 1032,0 сая төгрөгийн зээлийг олгосон ба үүний үр дүнд шинээр 5 үйлдвэр, 37 ажлын байр бий болоод байна.	100
39	“Сум хөгжүүлэх сан”-г “Хоршоог хөгжүүлэх сан” болгон өөрчлөх, улсын үзлэг зохион байгуулах, сангийн эргэн төлөлтийг сайжруулах	Улсын төсөв 0.8	Хоршооны улсын үзлэг зохион байгуулсан эсэх /тийм 1, үгүй 0/	0	1	“Хоршооны тухай хуульд орсон гол өөрчлөлтүүд”, “Хоршооны тухай хууль, холбогдох журмын дагуу хоршоодыг шинэчлэн бүртгэх тухай”, “Хоршооны гишүүний болон сумын засаг даргын эрх, үүрэг, хариуцлага” ,“Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, “Хоршооны дүрмийн өөрчлөлт” зэрэг сэдвийн хүрээнд 9 удаагийн танилцуулга, мэдээллийг 1815 хүнд өгсөн. Хоршооны улсын үзлэг буюу хоршоодын хөгжлийн үнэлгээнд	100

						110 хоршоог хамруулан үнэлгээ хийж холбогдох байгууллагад хүргүүллээ. 2022 онд хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийг барагдуулах зорилгоор Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өлзийт сумдад очиж ажилласан ба нийт 18 зээлдэгчийн зээлийг бүрэн төлүүлж Монгол банкны мэдээллийн санд муу зээлдэгч ангилалд бүртгэгдсэнийг засууллаа.	
40	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, загвар хоршоодыг байгуулах	-	Загвар хоршооны тоо	1	1	2022 онд ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс Өлзийт сумын Буян булаг өрнөх хоршоо эсгийний үйлдвэр, Сайхан-Овоо сумын Их бадрах хайрхан хоршоо мал нядалгааны цех, байгуулахаар 100,0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Хоршоо болох хүсэлтэй 10 гаруй иргэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсний үр дүнд Ажирхайн оргил, Их бадрах хайрхан, Онги нутгийн буян, Загийн алим эко, Голын цагаан овоо, Гурван өндрийн шим хоршоод шинээр байгуулагдсан бол Гурвансайхан сумын “Давших зам” хоршоо улсын тэргүүний загвар хоршооны шаардлагыг бүрэн хангаж материалаа хүргүүлээд хүлээгдэж байна.	100
41	“Хоршооны хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хоршоодыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	ЖДҮХСан, СХСан, бусад Төсөл хөтөлбөр	Дэмжлэгт хамрагдсан хоршооны тоо	1	3	Сумдын мэргэжилтнүүд болон давхардсан тоогоор нийт 1800 гаруй хоршоо, малчдын төлөөлөлд “Хоршооны тухай хуульд орсон гол өөрчлөлтүүд”, “Хоршооны тухай хууль, холбогдох журмын дагуу хоршоодыг шинэчлэн бүртгэх тухай”, “Хоршооны гишүүний болон сумын засаг даргын эрх, үүрэг, хариуцлага”, “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, “Хоршооны дүрмийн өөрчлөлт, улсын шилдэг хоршоо шалгаруулах журам” зэрэг сэдвийн хүрээнд танилцуулга, мэдээлэл олгох 7 удаагийн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ онд нийт шинээр хоршоо	100

						байгуулахаар 10 гаруй иргэн мэргэжил арга зүйн, 5 хоршоо санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.	
42	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулах	-	Бойжуулсан иргэн, ААНэгжийн тоо	0	10	20 бизнес эрхлэгчийг зөвлөгөө мэдээллээр хангаснаар шинээр 18 иргэн үйл ажиллагаагаа өргөтгөн хуулийн этгээд болж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэгдсэн. Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулах, үйлдвэрлэлийг өргөтгөх зорилгоор Төв аймгийн Баянчандмань сумын сүү, тахиа, хүлэмж, нойтон сальфетканы үйлдвэр, Улаанбаатар болон Хэнтий аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сумдад зохион байгуулагдсан аялалд 10 үйлдвэрлэгч хүнийг хамрууллаа. Дундговь аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувь нь гэрээр болон зориулалтын бус байранд үйлдвэрлэл, үйлчилгээгээ эрхэлдэг, түрээс өндөр төлдөг зэрэг асуудлыг шийдвэрлэж иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн 542,6 сая төгрөгийн санхүүжилтээр МСҮТ-ийн ашиглалтгүй байсан барилгыг засварлаж жижиг дунд бизнес эрхлэгчдэд түрээс төлбөргүйгээр ашиглалтын зардлыг хариуцуулан ашиглуулах "Бизнес хөгжлийг дэмжих төв"-ийн барилгын засварын ажлыг "Ашид бьюлдинг" ХХК гүйцэтгэж байна. Барилгын ажлын явц 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд энэ онд багтаан дуусгахаар ажиллаж байна.	100
43	Гарааны бизнесийг хөгжүүлэх, инновацын технологийг нэвтрүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	ЖДҮХСан, СХСан, бусад төсөл хөтөлбөр	Гарааны бизнес эрхлэгчийн тоо	0	2	2022 онд шинээр үйлдвэр эрхлэхээр гарааны зээл авсан 4 үйлдвэр, 13 ажлын байр бий болоод байна. Тухайлбал: Өлзийт сумын Буян булаг өрнөх хоршоо эсгийний үйлдвэр, Сайхан-Овоо сумын Их бадрах хайрхан хоршоо мал нядалгааны цех, Адаацаг сумын Ихэр улааны цохио, ХХК сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, Говь-Угтаал сумын Үржих эрдэнэ дэвжих ХХК туслах аж ахуй хөгжүүлэхээр дэмжлэг авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.	100

						Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, зах зээлд зуучлах “Дундговьд үйлдвэрлэв” борлуулалтын төвтэй болсноор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломж бүрдэж өнөөгийн байдлаар 130 гаруй үйлдвэрлэгч бараа бүтээгдэхүүнээ дэлгэн 142,0 сая төгрөгийн борлуулалт хийжээ.	
Малын удмын сангийн чиглэлээр							
44	Цэвэр үүлдрийн болон гойд ашиг шимт малын үрээр малчид, аж ахуйн нэгжийн малд зохиомол хээлтүүлэг хийж, малын үржлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	Хувь хөрөнгө	Зохиомол хээлтүүлэг хийсэн малын тоо	400	500	Сайнцагаан омгийн 350, Баянжаргалан, Дэрэн сумын 100 эм хонинд суффолк хуцны үрээр зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Энэ онд нийт 450 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийлээ.	75
			Өсөлтийн эрчим хувь	0	3	Зохиомол хээлтүүлэг хийснээр монгол хурганы амьдын жингээс өсөлтийн эрчим 3-5 хувиар нэмэгдсэн.	
45	Малын удмын сангийн үндэсний төвийн ЦССНэгжийн харьяанд байгаа өмч хөрөнгийг ХХААГазарт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	ОНТ	Орон нутгийн өмчид шилжүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/	0	1	Малын удмын сангийн үндэсний төвөөс ажлын хэсэг ирж ЦССНэгжийн харьяанд байгаа өмч хөрөнгөтэй танилцаж ХХААГазарт шилжүүлэх ажлыг 2023 онд зохион байгуулахаар болсон.	50
Судалгаа хөгжлийн төвийн чиглэлээр							
46	Малын дайвар түүхий эдээс эмийн үлдэгдэл илрүүлэх судалгаа, дайвар түүхий эдээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх туршилт хийх	УТ 1,0	Судалгаа хийгдсэн дээжийн тоо	-	50	Малын дайвар бүтээгдэхүүний түүхий эдийн дээжийг мах 8, өлөн гэдэс 2 авч улсын МЭАЦТЛ-т хүргүүлсэн. 55 мах, 79 сүүний сорьцод эмийн үлдэгдлийг илрүүлэх шинжилгээ хийсэн.	100

47	Газар тариалангийн үйлдвэрлэлд Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх, экстейншиний талбайн сургалт зохион байгуулах	УТ 4,5	Талбайн сургалтын тоо	-	1	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон "Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв", Жайка ОУБ-ын "SHEP" буюу "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Хүнсний ногооны тариалан эрхлэх, ногооны аж ахуйг хөгжүүлэх арга сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад хүнсний ногоо тариалах сонирхолтой 11 сумын 66 тариалан эрхлэгчид хамрагдсан.	100
48	Арьс ширэн түүхий эдийн гэмтлийг бууруулах, мөшгөх тогтолцоог нэвтрүүлэх судалгаа туршилт	УТ 5.0	Судалгаа хийсэн арьс ширний тоо	-	Бог-100 Бод-50	Судалгаа хөгжлийн хүрээлэнгийн судлаачдын баг 11 сарын 14-16-ны өдрүүдэд арьс, малын ашиг шимийг түвшин, махны дээжүүдийг бэлтгэн лабораторид судлахаар дээжийг авсан.	70
Хэрэгжилтийн дундаж хувь							90.9

Хянасан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хяналт шинжилгээ хийсэн:

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн
ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг

Биелэлт гаргасан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ – ийн мэргэжилтэн

Х.Дашням